



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН САЙД

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,
Цахим шуудан: letter@moe.gov.mn,
Цахим хуудас: www.moe.gov.mn

2025.09.12 № 1/4184

танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ЭРДЭНЭБОЛД ТАНАА

Улсын Их Хурлын гишүүн Таны 2025 оны
08 дугаар сарын 28-ны өдрийн 35 тоот албан
бичгээр ирүүлсэн “Боловсролтой монгол хүний
баталгааг хангах талаар” асуулгатай танилцлаа.

Асуулгатай холбоотойгоор мэдээллийг
хавсралтаар хүргүүлж байна.



П.НАРАНБАЯР

14255 1566

Боловсролын сайдын 2025 оны
09 дүээр сарын 12 өдрийн
1/418 тоот албан бичгийн хавсралт

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ЭРДЭНЭБОЛДЫН
“БОЛОВСРОЛТОЙ МОНГОЛ ХҮНИЙ БАТАЛГААГ ХАНГАХ ТАЛААР”
АСУУЛГЫН ХАРИУ

Нэг. Үндсэн хуульд заасан “сурч боловсрох”, “боловсролыг төлбөргүй олгох”, “төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулах” гэсэн асуудалтай холбоотой иргэний эрхийн хэрэгжилт ямар түвшин байгаа тухай; эдгээр асуудлын хүрээн дэх төрийн бодлого, хэрэгжилтийн үр дүн, иргэний сурч боловсрох эрхийн зөрчлийг арилгах, хэрэгжилтийг хангах зорилгоор богино болон дунд хугацаанд төлөвлөж буй зорилт, арга хэмжээний тухайд

Монгол Улсын Үндсэн хуульд “7/сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно” гэж заасан.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар батлагдсан Боловсролын ерөнхий хуульд боловсролын зорилгыг хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах” боломжийг олгоход чиглэж, боловсролын бодлого, үйл ажиллагаандаа тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн байх зарчмыг баримтлахаар хуульчилсан.

Түүнчлэн уг хуулийн “38.5.1.холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн нэг суралцагчид олгох хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх, ингэхдээ үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд гэрээний гүйцэтгэлд үндэслэн олгохоор заасан.

Хуулийн төслийг боловсруулах явцад Боловсролын ерөнхий хуулийн төслийг ЮНЕСКО-гоос эрхлэн гаргасан “Боловсрол эзэмших эрх” гарын авлагын сурч боловсрох эрхийг хөндсөн эрх зүйн баримт бичгийг үнэлэх 4А аргачлалын дагуу үнэлж, хэлэлцүүлж байсан болно.

Өнгөрсөн хичээлийн жилд буюу 2024-2025 оны хичээлийн жилийн албан ёсны статистик мэдээгээр төрийн бус өмчийн 640 боловсролын сургалтын байгууллагад 186,778 суралцагч боловсрол эзэмшиж байна. Өөрөөр хэлбэл, бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын 26.4-ийг эзлэх төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагад нийт суралцагчийн 14.9 хувь суралцаж байна.

Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 53 дугаар тогтоолын 1,2 дугаар хавсралтаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүн, 3 дугаар хавсралтаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулийн байршлаас хамаарах итгэлцүүр болон төрийн бус өмчийн ерөнхий

боловсролын сургуулийн жилийн нийт сургалтын төлбөрөөс хамаарах итгэлцүүр батлагдсан.

Засгийн газрын тогтоолд заасны дагуу үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн жилийн нийт сургалтын төлбөрөөс хамааран дараах итгэлцүүрийг баримтлан санхүүжилт олгож байна. Үүнд: төлбөргүй болон 1,000,000.0 төгрөг хүртэл төлбөртэй бол 1.0; 1,000,001.0-5,000,000.0 төгрөг хүртэл төлбөртэй бол 0.6; 5,000,001.0-10,000,000.0 төгрөг хүртэл төлбөртэй бол 0.5 гэсэн итгэлцүүлээр бодож, 10,000,001.0-ээс дээш төгрөгийн төлбөртэй бол 0.0 буюу хувьсах зардал олгохгүй байгаа.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн “Шалгуур батлах тухай” А/64 тушаалын хавсралтаар баталсан “Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд улсын төсвөөс хувьсах зардлын санхүүжилт олгох гэрээний үр дүнгийн шалгуурыг үнэлэх аргачлал”-д ялгаатай хэрэгцээтэй суралцагчийг тэгш хамран сургахтай холбоотой шалгуур туссан. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурч хөгжих тохируулгат орчин бүрдүүлэлт, сургуульд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, хэл, соёлын болон нийгэм, эдийн засгийн ялгаатай суралцагчдад үзүүлсэн нэмэлт үйлчилгээ, дэмжлэгтэй холбоотой шалгуурыг үнэлэх аргачлал орсон.

Аргачлалын дагуу гэрээний биелэлт, үр дүнгийн үнэлгээг үндэслэн гүйцэтгэлийн үр дүнг санхүүжүүлэх хувь хэмжээг тогтоосон.

Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын нийт 189 сургуулиас 166 сургуульд хувьсах зардлын санхүүжилт олгож байна. 2025 оны эхний хагаст хувьсах зардын санхүүжилтийг сар бүрийн хүүхдийн тооны ирцийн гүйцэтгэлд үндэслэн санхүүжилийн 80 хувь буюу 19,8 тэрбум төгрөгийн санхүүжилт, үлдсэн 20 хувийн санхүүжилтийг гэрээний хэрэгжилтийг үндэслэн нийт 4,9 тэрбум төгрөг олгохоос санхүүжсэн төсөвт багтаан 1,9 тэрбум төгрөгийн санхүүжилт нийт 21.7 тэрбум төгрөг олгосон.

Боловсролын яамнаас 2024 онд нийслэлийн ерөнхий боловсролын 20 гаруй төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, төлбөрт хяналт-шинжилгээ хийхэд сургуулиуд Монгол Улсын үндэсний сургалтын хөтөлбөр болон олон улсын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан. Сургалтын төлбөрийг тогтооход хамгийн их нөлөөлдөг хүчин зүйл бол цалин, олон улсын хөтөлбөрийн төлбөр байна. Мөн урсгал зардал, зээл, түүний хүүгийн төлбөр, бусад зардал нөлөөлдөг байна.

Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 2.3-д “хүүхдийн сурч боловсрох, хөгжих, оролцох, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасны дагуу хуулийн этгээдийг 1 сая төгрөгний торгуулийн арга хэмжээ авах боломжтой.

Боловсролын яаманд 2024-2025 оны хичээлийн жилд иргэдээс төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшийн ёс зүйн 6, сургалтын орчны аюулгүй байдлын 1, суралцах эрхийн 13 буюу сургуулийн орчинд хүүхдийн эрх зөрчигдөх, эрүүл мэнд хохирох, дарамт, ялгаварлан гадуурхалд өртөх зэрэг агуулга бүхий нийт 20 өргөдөл, гомдол ирсэн. Иймд хуулиар хүлээсэн эрх, үүргийнхээ хүрээнд холбогдох эрх бүхий албан тушаалтнууд нь хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлсэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, эрсдэлээс урьдчилан

сэргийлэх зорилгоор хяналт шалгалт хийж, 10 байгууллагыг хамруулан Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 2 байгууллага, 1 албан тушаалтанд шийтгэл оногдуулж, зөрчил дутагдлыг арилгуулахаар нийт 3 сургуулийн захиралд улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар үүрэг даалгавар өгч, гомдол гаргасан 8 иргэдэд тус яамны албан бичгээр хүргүүлж шийдвэрлэсэн.

Салбарын хэмжээнд боловсролын сургалтын байгууллагын орчин, дотуур байранд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, Хүүхэд хамгааллын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 23.2-т заасан арга хэмжээг авч ажиллаж байна.

Боловсролын сайдын 2024 оны А/121 дүгээр тушаалаар боловсролын салбарын хүүхдийн эрхийг хангах, үүнтэй холбогдох хуулт тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах дэд зөвлөл байгуулагдсан.

Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолын хавсралтаар баталсан сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүнд хүүхэд хамгааллын зардал багтан олгож байна.

Хоёр. Орчин үеийн шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжлийн эрин үе дэх нийгмийн болон бие хүний хөгжил, түүний дотор монгол хүний эрдэм боловсролын бодит эрэлт хэрэгцээг хангахад Монгол Улсын боловсролын салбарын эрх зүйн орчин хэр нийцэж байгаа; хүүхэд, залуучуудад хүртээмжтэй, чанартай боловсрол олгохын тулд, мөн хөтөлбөрийн агуулга, хэлбэр, арга зүйг шинэчлэн өөрчлөхийн тулд салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд баримтлан ажиллаж байгаа бодлого, стратегийн чиглэлийн тухайд

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д 2030 он гэхэд хүн бүрд тэгш хүртээмжтэй, чанартай, насан туршийн суралцахуйд суурилсан боловсролын тогтолцоог бэхжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэхийг зорьсон Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эрдэм боловсролтой Монгол хүн” зорилгын хүрээнд тэгш хүртээмжтэй, чанартай боловсролын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүд туссан.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 158 дугаар тогтоолоор 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарлаж, цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, Засгийн газарт хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Боловсролын хууль тогтоомжоор хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх зорилготой Монгол Улсын боловсрол нь бодлого, үйл ажиллагаандаа тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх, үндэсний болон хүн төрөлхтний нийтлэг соёл, үнэт зүйл, өв уламжлал, шинжлэх ухааны дэвшилтэт чиг хандлагад тулгуурласан байх, хүний эрх, эрх чөлөө, төрт ёс, түүх, соёлын уламжлал, үнэт зүйлсийг нандигнан өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахисан байх зэрэг зарчмыг баримталж байна.

Боловсролын ерөнхий хуульд хүүхдийг таван настайд нь сургуулийн өмнөх боловсролд, цаашид ерөнхий боловсролд заавал хамруулахаар хуульчилсан.

Боловсролын хууль тогтоомжоор суралцагч “ялгаатай хэрэгцэнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдах эрхтэй. Ингэхдээ “ялгаатай хэрэгцээ” гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг авч үзэхээр заасан.

Эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан боловсролоос орхигдсон бүлгийг “хүний эрхийн түгээмэл баталгаатай боловч бодит орчинд хэрэгжих боломжгүй байгаа бүлэг” гэж тодорхойлсон бол Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/553 дугаар тушаалаар батлагдсан “Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэл”-д зорилтот бүлгийг дараах байдлаар ангилсан. Үүнд: хөгжлийн бэрхшээлтэй; алслагдсан болон малчин өрхийн; шилжин суурьшсан өрхийн; үндэстний цөөнх, хэл, соёлын ялгаатай бүлгийн; ядуу, орлого багатай өрхийнд сургуулийн гадна байгаа болон сургууль завсардсан; сурлагын хоцрогдолтой; эрх нь хязгаарлагдсан; асрамж, халамжийн газарт байгаа; хилийн чанадад байгаа; бэлгийн цөөнх, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, залуус, иргэд гэж тодорхойлсон.

Түүнчлэн насан туршийн суралцахуйн хүрээнд хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлдөө нийцүүлэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа албан, албан бус сургалтаар болон амьдралын орчинд суралцах замаар тасралтгүй хөгжүүлэх, дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хүн амын тодорхой бүлгүүд боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа ба эдгээр хүмүүсийг Насан туршийн суралцахуйн төвөөр дамжуулан бичиг үсэг болон ерөнхий боловсролыг нөхөн эзэмшүүлэх сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулж байна. 2024-2025 оны хичээлийн жилд боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр нийт 5663 суралцагч, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 453, сүм, хийдэд 319, малчин өрхийн 2407, эрх нь хязгаарлагдсан 120 иргэн суралцлаа. Боловсрол нөхөн олгох сургалтад хамрагдсан суралцагчдыг насны байдлаар авч үзвэл 18-аас доош насны 2885, 18-аас дээш насны 2778 иргэн суралцсан. Үүнийг өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулвал 568 суралцагч буюу 10 хувиар нэмэгдсэн байна.

Боловсролын сайдын 2024 оны А/81 дүгээр тушаалаар “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад ганцаарчилсан сургалт зохион байгуулах журам”, Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/85, А/55, А/49 дүгээр хамтарсан тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм” тус тус батлагдсан.

Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамран сургах тойрог харгалзахгүйгээр боловсролын үйлчилгээнд хамруулж, суралцагчийн бэрхшээлийн онцлог, хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэн хөгжлийг дэмжих ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг эцэг эх асран хамгаалагч, суралцагч, багш хамтран боловсруулж, хэрэгжүүлэх боломж нөхцөл бүрдсэн.

Боловсролын сайдын 2025 оны А/229 дүгээр тушаалаар “Хос хэлний боловсрол, сургалт зохион байгуулахад баримтлах чиглэл” батлагдсан. Энэхүү чиглэл батлагдсанаар Казах, Тува хүүхдэд эх хэлээрээ болон төрийн албан ёсны хэлээр чанартай, хүртээмжтэй боловсрол эзэмшиж, сурч хөгжих тогтолцоо бүрдсэн.

Боловсролын сайдын 2025 оны А/77 дугаар тушаалаар “Малчин өрхийн гишүүний боловсрол, сургалтыг дэмжих” арга хэмжээг баталсан. Арга хэмжээний хүрээнд малчин өрхийн гишүүнийг боловсрол, сургалтад хамруулах, хөгжлийг дэмжих, тэдний бие даан бизнес эрхлэх, энтрепренер ур чадвараа хөгжүүлэхэд сургалт, үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд 2028 он гэхэд малчин 6-18 хүртэлх настай хүүхдийн ерөнхий боловсролд хамрагдалт, бүрэн дунд боловсрол эзэмшсэн малчин өрхийн гишүүний эзлэх жин нэмэгдэх болно.

Тус арга хэмжээг 2024-2028 он хүртэл 21 аймгуудад үе шаттай хэрэгжүүлэхээр арга хэмжээнд тусгасан. Малчин өрхийн гишүүний боловсрол, сургалтыг дэмжих арга хэмжээг 2025 онд зүүн бүсийн (Хэнтий, Дорнод, Сүхбаатар) аймгуудад хэрэгжүүлэхээр Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 11-ний А/98 дугаар тушаалаар 150 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэлээ. Энэхүү санхүүжилтээр Зүүн бүсийн малчин өрхийн гишүүний боловсролд хамрагдалтын тандалт судалгаа хийх, тухайн орон нутгийн Политехник коллежтой хамтран мал аж ахуйн чадамжийн гэрчилгээ олгох сургалтыг хамран зохион байгуулах, энтрепренерт суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх сургалт, малчин-залуу манлайлагч сургалтыг тус тус зохион байгуулахаар тусгасан зэрэг арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Боловсролын ерөнхий хуулиар бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлэх агуулгыг тодорхой зааж өгсөн. Тухайлбал, хүний эрхийн боловсрол, жендэрийн эрх тэгш байдал; хүмүүнлэг иргэн, тогтвортой хөгжлийн боловсрол; хувь хүн, гэр бүлийн төлөвшил, амьдрах ухаан, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл; монголын түүх, монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, төлөвшил зэрэг агуулга үүнд багтсан болно.

Мөн энэ хуулиар ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулгын мөрдөх хугацаа нь батлагдсанаас хойш ерөнхий боловсрол эзэмшүүлэх хугацаагаар тогтвортой байхаар хуульчилсанаар сургалтын хөтөлбөр, түүнийг дагаад сурах бичиг ойр ойрхон өөрчлөгдөхөөргүй болсон.

Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал” батлагдсан. Үзэл баримтлалд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд суралцагчийн хөгжлийн онцлогт нийцүүлэн суралцахуйн загварын, бодит суралцахуйн, конструктивист болон хувилбарт сургалтын онолын үндсэн дээр боловсруулсан сургалтын идэвхтэй аргыг хэрэглэнэ гэж заасан. Идэвхтэй сургалтын арга зүйг танхимын болон танхимын бус, холимог сургалтад цахим технологитой хослуулан хэрэглэх эрх зүйн орчин бүрдсэн.

Тухайлбал, сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан сургалтад тоглоомд суурилсан, зохиолд суурилсан арга зүй; бага ангийн сургалтад тоглоомын, орчинд суурилсан, шинжлэн судлах арга зүй; дунд ангийн сургалтад асуудалд суурилсан болон шинжлэн судлах арга зүй, орчинд суурилсан болон хамтран суралцах арга зүй; ахлах ангийн сургалтад асуудал болон төсөлд суурилсан арга зүй, шинжлэн судлах болон оролцоонд суурилсан арга зүйг ашиглана.

2023-2024 оны хичээлийн жилээс сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн үе шаттайгаар эхлүүлсэн.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд заасны дагуу сургуулийн өмнөх боловсролын агуулгыг хөдөлгөөн, бие бялдар, эрүүл мэнд, хэл яриа, математикийн болон цахим технологийн энгийн төсөөлөл, хүрээлэн байгаа орчин, урлагийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх, харилцааны зөв дадал, хэвшил төлөвшүүлэх чиглэлээр тогтоож, 2025-2026 оны хичээлийн жилээс сургуулийн өмнөх боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөр үндэсний хэмжээнд хэрэгжиж эхлээд байна.

2026-2027 оны хичээлийн жилээс бага боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөр хэрэгжинэ.

Ерөнхий боловсролын агуулгыг математик, байгалийн ухааны, нийгэм, хүмүүнлэгийн, хэл, харилцааны, бие бялдарын, урлаг, гоо зүйн, цахим болон зохион бүтээх технологийн, иргэний боловсрол, амьдрах ухааны мэдлэг, чадварыг хөгжүүлэх чиглэлээр тогтооно.

Хөдөлмөрийн зах зээлд ойрмогхон гарах энэ өөрчлөлтөд Монгол Улсын боловсролын тогтолцоо хариу үзүүлэхийн тулд технологид суурилсан бие даан суралцахуйд үе шаттай шилжих цахим шилжилтийг эхлүүлээд байна. Энэ шилжилтийг хийхэд өндөр хурдны интернэт, ухаалаг төхөөрөмжийн хүртээмж, цахим сургалт, контентын нээлттэй сан, сургалтыг чиглүүлэх, дэмжих шинэ ур чадвартай багш, шинэчлэгдсэн сургалтын хөтөлбөр бэлэн болсон байх шаардлагатай юм.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд суралцагчийн унших, үзэх, сонсох идэвхтэй үйлийг дэмжсэн, бие даан ажиллах боломжтой цахим хэрэглэгдэхүүн, сургалтын нээлттэй материал, интерактив контент, платформыг ашиглаж эхлээд байна.

2023 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсэн Мэдлэ цахим сургалт энэ чиглэлээр Монгол улсад төдийгүй дэлхийн зарим оронд сайн туршлага болж байна. Бидэнд энэхүү сургалтыг Пакистан, Индонез зэрэг улсад хамтран нэвтрүүлэх саналыг эдгээр улсын Боловсролын яам болон Гүүгл компаниас ирүүлээд байна. 2024-2025 оны хичээлийн жилд Мэдлэ цахим сургалтад аймаг, сумын ерөнхий боловсролын сургуулийн 10, 11, 12 дугаар ангийн 36,941 суралцагч хамрагдаж, сонгон судлах хичээлүүдээ судаллаа.

Түүнчлэн 2024 оны 5 дугаар сараас ерөнхий боловсролын I-V ангийн нийт 33 сурах бичгийг бүрэн дижитал, интерактив болгож www.sur.esis.edu.mn системийг хөгжүүлсэн, багшийг виртуаль туслахтай болгох ажлыг эхлүүлсэн зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

Гурав. Боловсролын үйлчилгээг хүүхэд бүрд жигд хүртээмжтэй, чанартай олгох үйлсэд салбарын төсөв, хөрөнгө оруулалт санхүүжилтийн хувьд баталгаа болж чадаж байгаа эсэх; сүүлийн 10 жилд улсын нэгдсэн төсвөөс боловсролын салбарын хөгжилд зориулсан зарцуулсан зарцуулалтын хэмжээ, дотоодын нийт бүтээгдэхүүнд болон улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь, бүтэц, зориулалт, үр нөлөө болон үр дүнгийн талаар шинжилгээ хийсэн шинжилгээ; цаашид эрдэм боловсролтой монгол хүнийг төлөвшүүлэхэд чиглэсэн төсөв, санхүүгийн баталгааг бүрдүүлэхийн тулд баримтлах зарчим, бодлогын тухайд

Боловсролын хүртээмж, чанарыг сайжруулж, хүүхэд бүрд жигд хүртээмжтэй, чанартай боловсролыг эзэмшүүлэхэд боловсролын салбарын төсөв, хөрөнгө оруулалт чухал билээ.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээгээр сүүлийн 10 жилийн байдлаар авч үзвэл

Төрөл	2015	2016	2017	2018	2019
Улсын нэгдсэн төсвийн нийт зардал, сая төгрөг	7,137,974	9,495,333	9,017,319	9,317,221	11,661,701
Боловсролын зардал, сая төгрөг	1,000,712	1,222,237	1,213,714	1,455,271	1,745,790
Улсын нэгдсэн төсвийн нийт зардалд боловсролын зардлын эзлэх хувь	14	12.9	13.5	15.6	15

Төрөл	2020	2021	2022	2023	2024
Улсын нэгдсэн төсвийн нийт зардал, сая төгрөг	13,904,273	15,630,444	18,159,669	22,509,000	30,365,473
Боловсролын зардал, сая төгрөг	1,552,982	1,652,014	2,223,687	3,033,744	3,683,221
Улсын нэгдсэн төсвийн нийт зардалд боловсролын зардлын эзлэх хувь	11.2	10.6	12.2	13.5	12.1

Цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь салбарын тулгамдсан асуудал болж байна.

2024-2025 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын 2,292 байгууллагад 1,062,723 суралцагч суралцлаа. Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийн 93-аас дээш хувь нь боловсролын үйлчилгээнд хамрагдсан байна. Хэдийгээр хамран сургалт өндөр байгаа ч хүн амын төвлөрөл ихтэй нийслэл болон зарим аймагт цэцэрлэг, сургуулийн хүртээмж хангалтгүйгээс анги танхимын ачаалал их, бүлэг дүүргэлт өндөр, үүнээс шалтгаалан сургалтын чанар хангалтгүй байна.

Хүүхдийн тооны өсөлтийн хамгийн оргил үе 2028-2030 онд тохиохоор байна. Сургууль, цэцэрлэгийн барилгыг барих хугацаа дунджаар 3-5 орчим жил байдаг гэж үзвэл энэ оргил үеийг давах бэлтгэлийг одооноос хийх шаардлагатай бөгөөд урьдчилсан тооцооллоор сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд 2028 он хүртэл 15,720 орны хүчин чадалтай 95 цэцэрлэг, 66,910 суудлын хүчин чадал бүхий 108 сургууль барих шаардлагатай байна.

Хүүхдийн тооны өсөлттэй уялдуулан сургууль, цэцэрлэгийн барилгыг төлөвлөж хөрөнгө оруулалт хийж байгаа ч энэ өсөлтийг гүйцэхгүй байна. 2022-2024 онд 49,925 хүүхдийн хүчин чадалтай 173 сургууль, цэцэрлэгийн барилга

ашиглалтад орсон ба 2025 онд 20,352 хүүхдийн хүчин чадал бүхий 72 боловсролын барилга байгууламж төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орохоор байна. Монгол Улсын 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төсөлд 45 цэцэрлэг, 45 сургуулийн барилгыг шинээр эхлүүлэхээр тусгасан, үүнд 701,405.26 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаагаас 157,373.0 сая төгрөгийн санхүүжилтийн дутагдал үүсэхээр байна.

Хүртээмжтэй холбоотой асуудал сургалтын чанарт сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй, хүүхэд хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдах, хөгжих боломжийг хязгаарлаж байна.

Монгол Улс 2022 онд анх удаа оролцсон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас зохион байгуулдаг PISA (Programme for International Student Assessment) суурь боловсрол эзэмшсэн 15 настай суралцагчид танхимаар олж авсан мэдлэг, чадвараа амьдрал дээр хэрхэн хэрэглэж байгаа, тухайн улсын боловсролын тогтолцоо энэ чадварыг ямар хэмжээнд олгож байгааг тандан судалдаг сурлагын амжилтын үнэлгээнээс сургуулийн ээлжийн коэффициент 1 болж ачаалал буурахад суралцагчийн математикийн оноо 8-аар нэмэгддэг болохыг тогтоосон. Сургууль нэг ээлжтэй болох нь хүүхдийн цогц хөгжлийг хангах, сургалтын чанар сайжрах, сургуулийн ачаалал бууруулахад түлхэц болно.

Цаашид эрдэм боловсролтой монгол хүнийг төлөвшүүлэхэд чиглэсэн төсөв, санхүүгийн баталгааг бүрдүүлэхийн тулд улсын төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг тууштай нэмэгдүүлэхээс гадна Азийн хөгжлийн банк гэх мэт донор байгууллагын хөнгөлөлттэй зээлээр шийдвэрлэхээр ажиллаж байна.

Дөрөв. Багш нарын цалин, урамшууллыг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл боломжийг хангах чиглэлээр ойрын хугацаанд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй томоохон өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, арга хэмжээний тухайд

Боловсролын чанарын ялгааг бууруулахад багшийн хангалт, чанар үндсэн хүчин зүйл юм.

Боловсролын ерөнхий хуульд мэргэжлийн тасралтгүй хөгжил, нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн тодорхой зохицуулалт туссан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “2.2.Эрдэм боловсролтой монгол хүн” хэсгийн “2.2.3.Багшлах хүний нөөц” зорилгын хүрээнд багшийн чанар, хүртээмж, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн нийт 4 зорилтыг хэрэгжүүлэхээр заасан.

Боловсролын яамнаас багшийн чанар, мэргэжлийн чадамжийг сайжруулах, тасралтгүй хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, Засгийн газрын 2024 оны 192 дугаар тогтоолоор “Багшийн гурван тулгуурт бодлого” цогц арга хэмжээ-г батлуулсан.

Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын багшийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн уг арга хэмжээ хэрэгжсэнээр боловсролын сургалтын байгууллагын мэргэжлийн багшийн хангалт 100 хувьд хүргэх, багшийн нийгмийн баталгаа, цалин хөлсний талаарх сэтгэл

ханамжийн түвшинд жил бүр ахиц гарч, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэжлийн мэдлэг, ур чадварын үнэлгээний үр дүнд ахиц гарч, багшийн цалин хөлсний дундаж хэмжээг улсын дундаж хэмжээнд хүргэн нэг багшид ногдох суралцагчийн улсын дундаж 20-д хүргэхээр ажиллаж байна.

2024-2025 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр төрийн өмчийн цэцэрлэгийн мэргэжлийн багшийн хангалт 93.7 хувь, ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт 97.1 хувьтай байгаа ч багшийн дутагдалгүй байгаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн эзлэх жин хангалтгүй байна.

Сургууль, цэцэрлэгийн ачаалал багш нар тэр дундаа залуу багш нараас ажлаас гарах шалтгаануудын нэг болж байна.

Сүүлийн 10 жилийн статистик мэдээллээс харахад багш мэргэжлээр төгсөгчдийн 33 орчим хувь нь багшийн ажил эрхэлдэг, багшийн ажилд орсон залуу багш нарын 60 орчим хувь нь 6 жилийн дотор ажлаас гарч эсвэл шилжиж байна. "Боловсролыг дэмжих жил"-ийн хүрээнд байгуулагдсан Ажлын хэсэг багшийн цалин хөлс, нийгмийн баталгаанд дүн шинжилгээ хийж үзэхэд саяас доош цалинтай, нийгмийн баталгааны үр шимийг төдийлөн хүртдэггүй багш нарын дунд залуу багш дийлэнх нь байна. Тэдэнд орон сууцны дэмжлэг шаардлагатай байна.

Багш бэлтгэх сургалтын чанарыг сайжруулалгүйгээр багшийн чанарыг сайжруулах боломжгүй юм. Багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын сургалт, үйл ажиллагаа, судалгааны орчинд томоохон хөрөнгө оруулалт хийгээгүй ирсний улмаас төгсөгчдийн чанар харилцан адилгүй, боловсролын шинэчлэлд бэлэн бус төгсөгчид гарч байна. Багшийн чанарыг сайжруулах, тасралтгүй хөгжлийг хангахад багш бэлтгэх их сургууль, коллежийн хөтөлбөр, сургалт, үйл ажиллагааг шинэчлэх шаардлагатай байна. Шинэчлэл хийхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг төсвийн болон гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар шийдэх боломжтой юм.

Багш нарын дунд хийсэн сэтгэл ханамжийн судалгаанаас ажилдаа тогтвор суурьшилтай, үр дүн гаргаж ажиллахад хамгийн чухал нь цалин хөлс байна. Боловсролын цахим шилжилт, хүүхэд хамгаалал, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой багшийн ажил үүрэг нэмэгдэж байгаа бөгөөд энэ нэмэлт ажилтай холбоотой багшийн цалин хөлсний бүтцийг эргэж харах хэрэгцээ байна.

---oOo---